



НИЙСЛЭЛИЙН БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 19 өдөр

Дугаар А/192

Улаанбаатар хот

Нийтийн эзэмшлийн усан оргилуурт
засвар үйлчилгээ хийх, хэвийн ажиллагааг
хангах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дугаар зүйлийн 14.1.17 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Иргэдийн амралт, чөлөөт цагийг зөв боловсон, ая тухтай өнгөрүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор дүүргийн нутаг дэвсгэр дэх усан оргилуурыг засварлаж, 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн ажиллуулсугай.

2.Дүүргийн 2 дугаар хороо, “Тээврийн дээд сургууль”-ийн өмнөх, “Ардчилалын өндөрлөг” дэх, 4 дүгээр хороо, “Төмөр замын төв буудал”-ын хойд тал, 15 дугаар хороо, “Байгаль эх цогцолбор”-ын усан оргилууруудад засварын ажлыг хийлгэж, хэвийн ажиллагаанд оруулж ажиллахыг Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс (Г.Мөнх-Эрдэнэ)-т даалгасугай.

3.Дээрх ажилд шаардагдах санхүүжилтийг Гэрэлтүүлэг, тохижилт үйлчилгээний тасгийн бусдаар гүйцэтгүүлэх, бусад нийтлэг ажил үйлчилгээний зардлаас гаргахыг Тамгын газар (Б.Нарангэрэл)-т зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эдийн засаг, худалдаа үйлчилгээ, тохижилт, нийтийн аж ахуйн асуудал хариуцсан төслийн удирдагч (Д.Мөнхбаатар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Ө.СУМЪЯАБААТАР

